



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ  
КОМПАНИУДАД

МОНГОЛ УЛСЫН  
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

Засгийн газрын XIV байр, Чингисийн өргөн чөлөө,  
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17060  
Утас: 26 30 51, Факс: (976) 7004 3479,  
Цахим шуудан: info@energy.gov.mn

2024. 09. 05 № 8/2721

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Тодруулга хүргүүлэх тухай

“Дулааны 1 дүгээр гол шугам ТК-1 худгаас ТК-3 худаг хүртэлх 2Ф400 мм голчтой дулааны магистраль шугамыг 2Ф800 мм голчтой болгох өргөтгөл /Дорнод, Хэрлэн сум/-ийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер тендерт оролцоо сонирхож буй компаниас ирүүлсэн тодруулгын дагуу дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

Асуулт 1.Тендерийн баримт бичгийн ТШЗ-ны 19.1-д “Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: Батлагдсан төсөвт өртийн үнийн дүнгийн 40 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй буюу Ф500 мм болон түүнээс дээш голчтой дулаан дамжуулах шугам сүлжээний барилга угсралтын ажлыг сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд доод тал нь 1 удаа гүйцэтгэсэн байна” гэж заасан. Иймд 2 ажлын нийлбэр дүнг ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагад тооцон үзэж болох талаар тодруулга өгнө үү.

Хариулт 1.Тендерийн баримт бичгийн ТШЗ-ны 19.1-д “Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: Батлагдсан төсөвт өртийн үнийн дүнгийн 40 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй буюу Ф500 мм болон түүнээс дээш голчтой дулаан дамжуулах шугам сүлжээний барилга угсралтын ажлыг сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд доод тал нь 1 удаа гүйцэтгэсэн байна” гэж заасан тул төсөвт өртийн үнийн дүнгийн 40 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг Ф500 мм болон түүнээс дээш голчтой дулаан дамжуулах шугам сүлжээний барилга угсралтын ажлуудын гэрээний үнийн дүнгийн нийлбэрээр тооцохгүй.

Асуулт 2.Сүүлийн 3 жилд хийж гүйцэтгэсэн Дулааны шугамын ажлын туршлагатай байх шаардлага тавигдсан байна. Манай компанийн хувьд бага үнийн дүнтэй Ф500 мм-ийн голчтой дулааны шугамын угсралтын ажлыг гүйцэтгэсэн туршлагатай ба томоохон хэмжээний ажлын хувьд УБ хотын төв магистрал шугам болох 11г,д шугамын угсралтын /1000мм голчтой/ ажлыг түншлэлийн компаниудын хамт гүйцэтгэхээр 2016 онд гэрээ байгуулан ажиллаж байна. Энэ төсөл нь өндөр үнийн дүнтэй ажиллагаа ихтэй /трассын хөндлөн болон дагууд нь цэвэр ус болон холбооны шугамууд таарсан, мөн объектууд таарсан/ ажил хэдий ч гэрээний үүргээ биелүүлэн захиалагчийн /НХОГ/ улсын төсөвт тусгагдсан санхүүжилтийн дагуу тухайн тайлант /2017, 2018, 2019/ онуудад ажлыг гүйцэтгэсэн ба өнөөг хүртэл үргэлжилсээр байна. Онцгой нөхцөл болох Ковид-19 цар тахлаас болж гүйцэтгэлийн ажил хойшлогдсон төдийгүй төсөвт шинэчлэлт хийгдэж гэрээнд өөрчлөлт оруулах зэрэг шалтгаануудын улмаас одоог хүртэл уг ажил үргэлжлэн

170600002790

хийгдэж байна. Иймд дээрх ажлыг /11г,д/ ижил төстэй томоохон хэмжээний ажлын туршлагад тооцогдох эсэхэд тодруулга авах хүсэлтэй байна.

Хариулт 2.Тендерийн баримт бичгийн ТШЗ-ны 19.1-д “Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: Батлагдсан төсөвт өртийн үнийн дүнгийн 40 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй буюу Ф500 мм болон түүнээс дээш голчтой дулаан дамжуулах шугам сүлжээний барилга угсралтын ажлыг сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд доод тал нь 1 удаа гүйцэтгэсэн байна” гэж, ТШЗ-ны 19.2-д “Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагыг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Гэрээний үнийн дүн болон хүчин чадлын туршлагад тооцуулах ижил төстэй ажлын гэрээ, улсын комиссоор хүлээж авсан дүгнэлтийн эхээс хийсэн хуулбар” гэж заасан тул үргэлжлэн хийгдэж байгаа дуусаагүй ажлыг ижил төстэй ажлын туршлагад тооцохгүй.

